

ЭКСОРС ХХК-ИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд байгаль хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд гарч байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгасан агуулга бүтэцтэй байх шаардлагатай.

Төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” Монгол Улсын хууль, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дугаар тушаалын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”, Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”-ын 2-р хэсэгт тусгасны дагуу, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэрэгт тулгуурлан боловсруулав.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 2.2-т заасны дагуу Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний ажлын үр дүнгээр боловсруулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үнэлгээний мэргэжлийн зөвлөл хэлэлцэн баталснаас хойш төсөл хэрэгжүүлэгч 1 сарын дотор тухайн жилийн БОМТф боловсруулан ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад батлуулахаар хүргүүлнэ.

Төсөл хэрэгжүүлэгч нь үйл ажиллагаандаа Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалын хавсралт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг дагаж мөрдөнө.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах. Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж, батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөлөөг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үндэслэн жил бүрийн 12 дугаар сард багтаан дараа оны тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулна. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон

нэмэлт тодотгол үнэлгээний ажлын үр дүнгээр боловсруулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үнэлгээний мэргэжлийн зөвлөл хэлэлцэн баталснаас хойш төсөл хэрэгжүүлэгч 1 сарын дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө боловсруулан ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад батлуулахаар хүргүүлнэ.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд төсөл хэрэгжүүлэгчийн талаарх мэдээлэл, төслийн танилцуулга, төслийн хэрэгжилтийн явц, ашиглаж байгаа техник технологи, төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга, энэ журмын 1.5-д заасан бүрдэл хэсгүүд, баримтлах хууль тогтоомж, стандартын шаардлага болон авч хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг тодорхой тусгана.

Төсөл хэрэгжүүлэгчийн хэрэгжүүлж буй төслийн үйл ажиллагаа нь зах зээл, эдийн засгийн хямрал, байгалийн гамшигт үзэгдэл, тухайн бүс нутаг, хүн амыг хамарсан халдварт өвчин, тахал зэрэг давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас зогсонги байдалд орсон бол энэ талаараа ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад давагдашгүй хүчин зүйл үүссэнээс хойш 1 сарын дотор хандан, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжгүй болсон талаараа мэдэгдэж, дээрх шалтгаан арилах хүртэл түр хойшлуулах хүсэлт гарган шийдвэрлүүлнэ. Тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй талаарх тодорхойлолтыг төсөл хэрэгжиж буй сум, дүүргийн Засаг дарга, хэд хэдэн сум, дүүргийн нутаг дэвсгэрт хэрэгжих төслийн хувьд аймаг, нийслэлийн байгаль орчны газар тодорхойлсон байна.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянаж, батлах. Тухайн төсөлд хийсэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд үндэслэн боловсруулсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага хянан баталснаар төслийн тухайн жилийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх үүснэ. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг энэхүү журамд заасан шаардлагыг хангаж боловсруулаагүй бол түүнийг хүлээн авч хянах, батлахаас татгалзах үндэслэл болно.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.8-д заасны дагуу төсөлд ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүлээн авч, түүнд хийсэн ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн биелэлтийг хянаж, дараагийн жилд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянаж батална. Ашигт малтмал ашиглах, хайх, дэд бүтцийн барилга байгууламж барих зэрэг улирлын шинж чанартай үйл ажиллагаа явуулдаг төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг тэдгээрийн тухайн оны төлөвлөлттэй уялдуулан эхний улиралд багтаан хянаж, эцэслэн батална.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах. Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ханган биелүүлж түүний үр дүнг тусгасан биелэлтийн тайланг 11 дүгээр

сарын 01-ний дотор энэхүү журмын 3-р хавсралтын дагуу гаргаж, харьяалагдах аймаг, нийслэлийн байгаль орчны газарт 3-аас доошгүй хэвлэмэл хувь болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

Аймаг, нийслэлийн байгаль орчны газар тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүлээн авсан талаарх мэдээллийг байгаль орчны менежментийн төлөвлөгөөний цахим мэдээллийн санд оруулж, хүлээн авсан тухайгаа төсөл хэрэгжүүлэгчийн бүртгүүлсэн цахим шууданд ажлын 5 хоногт багтаан хариу мэдэгдэнэ.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг газар дээр нь хянаж, дүгнэх ажлын хэсгийг харьяалагдах аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар энэ журмын 4.1-д заасан хугацаанд байгуулна. Ажлын хэсгийг тухайн аймаг, нийслэлийн байгаль орчны газрын дарга ахлах бөгөөд байгаль орчны газрын уул уурхайн асуудал хариуцсан мэргэжилтэн нарийн бичгийн дарга байна. Ажлын хэсэгт аймаг, нийслэлийн байгаль орчны газрын дарга, тухайн асуудлыг хариуцсан мэргэжилтэн, мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны асуудал хариуцсан улсын байцаагч, сав газрын захиргааны ус ашиглагч хариуцсан мэргэжилтэн, сум, дүүргийн байгаль орчны хяналтын улсын байцаагч, тухайн нутаг дэвсгэрийг хариуцсан байгаль хамгаалагч, нөлөөллийн бүсэд оршин сууж буй иргэдийн төлөөлөл орно.

Ажлын хэсгийн гишүүд нь төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг газар дээр нь шалгаж, үнэн зөв, бодит дүгнэлт гаргах чадвартай, байгаль орчны болон тухайн салбарын хууль тогтоомжийн талаар бүрэн мэдлэгтэй, ажлын туршлагатай хүн байна. Төслийн нөлөөллийн бүсэд оршин суух иргэдийн төлөөлөлд энэ шаардлага хамаарахгүй.

Ажлын хэсэг тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг газар дээр нь шалгаж, дүгнэх ажлыг 11 дүгээр сарын 30-ны дотор зохион байгуулж, зөвхөн батлагдсан төлөвлөгөөнд тусгасан ажлуудын гүйцэтгэлд үндэслэн төсөл хэрэгжүүлэгч байгууллагын төлөөллийг байлцуулан, энэхүү журмын 4-р хавсралтад заасны дагуу арга хэмжээний чиглэл тус бүрээр оноогоор тооцож, биелэлтийг нь нэгтгэн гаргаж, газар дээр нь баталгаажуулан гарын үсэг зурж, төсөл хэрэгжүүлэгчид 1 хувийг хадгалуулна.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг аймаг, нийслэлийн томилсон ажлын хэсэг газар дээр нь хянаж үнэлсэн нэгдсэн дүн 90 онооноос дээш гүйцэтгэлтэй байвал төсөл хэрэгжүүлэгчээс боловсруулж ирүүлсэн дараа жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянан батлах нэг нөхцөл болно. Аймаг, нийслэлийн Засаг дарга, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг газар дээр нь шалгаж, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг энэ журмын 4.1-т заасан хугацаанд байгуулж ажиллуулаагүй, ажлын хэсэг газар дээр нь ажиллаж нэгдсэн дүгнэлтээ энэ журмын 4.9-т заасан хугацаанд гаргаж ирүүлээгүй бол байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын тухайн асуудлыг хариуцсан нэгж ажлын хэсэг томилон дүгнэнэ. Энэ тухай холбогдох аймаг, нийслэлийн байгаль орчны газарт албан бичгээр мэдэгдэнэ.

Аймаг, нийслэлийн байгаль орчны газраас батлагдсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан арга хэмжээ, нөхөн сэргээх, бохирдсон болон доройтсон орчныг цэвэрлэх, сэргээх үүргээ биелүүлээгүй ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн талаарх мэдээллийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагад дүгнэлт гаргуулахаар хүргүүлж болно. Байгалийн нөөц, баялгийг ашиглан үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байгаа төсөл хэрэгжүүлэгч 2 жил тутамд байгаль орчны хуваарьт аудит хийлгэн, аудитын тайлан болон аудитын зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн ажлын тайланг аймаг, нийслэлийн байгаль орчны газарт ирүүлж, уг аудитын тайлан, зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн ажлын тайланд менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийн талаар бодит мэдээлэл, дүгнэлтийг тусгасан байх бөгөөд хугацааны хувьд давхцаж байвал тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага дүгнэх нөхцөл болгож болно.

Төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт 90 оноо хүрээгүй буюу, хангалтгүй гэж дүгнэгдсэн бол хангалтгүй хийгдсэн ажлыг дараа оны эхний улиралд багтаан гүйцэтгэсэн тохиолдолд дүгнэлтийг дахин гаргуулна. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөхөн сэргээлтийн ажлыг дутуу хийсэн бол үүнд хамаарахгүй. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний баталгаажих нүүр хуудасны загварыг журмын 1 дүгээр, биелэлтийн тайлангийн нүүр хуудасны загварыг журмын 2 дугаар, төлөвлөгөө болон биелэлтийн тайлангийн агуулгыг журмын 3 дугаар, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хүлээж авах, дүгнэх хуудасны загварыг журмын 4 дүгээр, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, биелэлтийн тайланг хүлээн авахад шаардлагатай бичиг баримтын бүрдлийг журмын 5 дугаар, уул уурхай, үйлдвэр, аялал жуулчлал, газар тариалан, үйлчилгээний салбарын төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хяналтын хуудсыг журмын 6 дугаар хавсралтад заасан загварын дагуу тус тус гаргана.

Бусад. Байгаль орчныг хамгаалах, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх барьцаа хөрөнгийг төвлөрүүлэх, буцаан олгохтой холбогдсон харилцааг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.15-д заасан журмаар зохицуулна. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг төсөл хэрэгжүүлэгч бүрэн хариуцна. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хүлээн авч дүгнэх, дараа жилийн төлөвлөгөөг хянан батлах асуудлыг ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага энэ журмын хавсралт 4 болон 6-д заасан баримт бичиг, мэдээллийн бүрдлийг үндэслэн ажлын 14 хоногт багтааж, шийдвэрлэнэ. Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг газар дээр нь шалгасан дүгнэлттэй холбоотой гомдлоо 12 дугаар сарын 15-ны дотор байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

Хүснэгт 1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Зардал /мян.төгрөг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээ	5100.0
2	Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2300.0
3	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	4000.0
4	Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр	3164.0
	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	14564.0

1.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 2. “Эксорс” ХХК-ийн Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутаг, Бог дхан уулын ДЦГ-ын Залаатын Зүүн богинын аманд хэрэгжүүлэх “аялагч, зөвшөөрөл бүхий хүн түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа, шинжилгээ хийх зориулалттай орон байр барих, ашиглах” төслийн сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болзошгүй сөрөг нөлөө ба	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Өртөг/мян.т	Баримтлах стандарт, аргачлал
				2026 он	
АГААРЫН ЧАНАР ҮЗҮҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ БАГАСГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ					
1	Дотоод болон гадаад орчны агаарын бохирдол	Дотоод орчны агаарын чанарыг хэмжих багаж суурилуулах	Байгууламжийн орчим	500.0	MNS 5010-2001 Тоос. Ажлын байрны агаар дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага.
2		Дуу чимээг стандартын түвшинд байлгах, давсан тохиолдолд эх үүсвэрийг тодорхойлж, багасгах арга хэмжээ авах.	Спортын цогцолбор орчим	500.0	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага. MNS 5885:2008 Агаар бохирдуулагч бодисын хүлцэх хэм хэмжээ, Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 5002:2000
3		Гадаад орчны агаарт дуу чимээ, хийн бохирдлыг хэмжих	Замын ойролцоо, төслийн талбайн гадна 100м орчимд	500.0	
ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УС, УСНЫ ЧАНАР ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БАГАСГАХ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ					

3	Байгууламж орчмын гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдуулах	Үерийн хамгаалалт, далан хийх	Төслийн хэмжээнд	Дотоод санхүүжилт ээр	MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. MNS 5667-2:2001 Усны чанар-Дээж авах-2-р бүлэг Дээж авах арга MNS 4867:1999 Усны чанар-Дээж авах-3-р бүлэг Авсан дээжийг зөөвөрлөх, хадгалах арга
4	Усны нөөц бага тул ариг гамтай хэрэглэх, усны нөөцийг багасахаас сэргийлэх	Төслийн үйл ажиллагаатай холбогдох зам, талбайд ус зайлуулах хоолой болон сувгуудыг зам, талбайн доор байгуулж, богино хугацаанд хуримтлагдах үерийн аливаа усыг зайлуулах		1000.0	Ундны усны эх үүсвэрийг тодорхойлон MNS 0900: 2005 “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ”
УРГАМЛЫН НӨМРӨГ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БАГАСГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ					
1	Орчны талбай дахь хөрс, ургамлын нөмрөг нөлөөлөлд өртөх	Ургамлын мониторинг судалгааг мэргэжлийн байгууллагаар жилд 1-2 удаа хийлгэж, үр дагаврыг тогтмол хянах	орчны бүсэд	1000.0	Ургамлын мониторинг хийх гадаад ба дотоодын судлаачдын гаргасан аргачлал, аргазүйг баримтална.
2	Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд авах арга хэмжээ				
	Мод тарих	Заасан талбайд	Заасан талбайд	1500.0	Нийслэлийн БОГ-тай хийсэн гэрээг үндэслэнэ.
ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ					

1	Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлыг ил задгай	Хог хаягдлын менежмент төлөвлөгөө боловсруулж мөрдөж ажиллах	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгав. Хог хаягдлыг БОННУ-нд заасан зөвлөмжийн дагуу гэрээ хийх, устгах	Хог хаягдлын тухай хууль
2	хаяснаар хөрс бохирдох	Хог хаягдлын сав, цэгийн тохижуулах	Төслийн хэмжээнд Дотоод төлөвлөлтөөр	100.0
УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ				
1	Хүний эрүүл мэнд	Ажиллагсдыг тусгай хувцас хэрэгслээр ¹ бүрэн хангах	Дотоод төлөвлөлтөөр	Хөдөлмөрийн тухай хууль Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Хамгаалалтын хувцас ерөнхий шаардлага.MNS (ISO) 13688:2000 Гал түймрээс хамгаалах. MNS
2		Ажиллагсдыг эмнэлгийн нарийн мэргэжлийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах		
3		Нэг бүрийн хамгаалах хэрэгслээр ² хангах		
4	Төслөөс байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл	Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах	Үйл ажиллагааны дотоод төлөвлөлтөөр	Галын аюулгүй байдлын тухай хууль Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргах журам
5		Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд дүгнэлт гаргуулах	Үйл ажиллагааны дотоод төлөвлөлтөөр	Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/223 дугаар тушаал, Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам

¹ “Тусгай хувцас” гэж үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс ажилтныг хамгаалах зориулалт бүхий хувцас, гутал, малгай, бээлий зэрэг хэрэгслийг хэлнэ.

² “Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл” гэж үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс ажилтныг хамгаалах зориулалт бүхий хэрэгслийг хэлнэ.

		ҮАЗ-д		
СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ НИЙТ ЗАРДАЛ			5100.0	

1.2. Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Энэхүү төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу хийсэн байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах зардлыг тусгалаа.

Эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан болзошгүй осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэхэд MNS 6010:2009 Гамшгийн холбогдолтой нэр томьёо, тодорхойлолт, ерөнхий анги, MNS 4244:1994 Хөдөлмөр хамгааллын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага, MNS 5390:2004 Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага, MNS 4968:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага, MNS 4996:2000 Ажлын байрны гэрэлтүүлгийн норм, хэмжих аргад тавих ерөнхий шаардлага, MNS 5247:2003 Барилга байгууламжийн гал унтраах ус түгээгүүрийн зэрэг стандартуудыг баримтлан ажиллах шаардлагатай болно.

Хүснэгт 3. Болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах зардал

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Баримтлах стандарт, аргачлал
Болзошгүй осол				
Аялагчдын машинаас нефтийн бүтээгдэхүүн асгарах	Нефтийн бүтээгдэхүүн асгарч, алдагдсан үед авах арга хэмжээ, хувийн хамгаалах хэрэгсэл, анхны тусламж, галын аюулын үед авах арга хэмжээний талаар байгууллагын ажилтан ажиллагсдад сургалтад хамруулах	Байгууллагын ажиллагсад ажилтнууд	2000.000	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг MNS 5029:2011

Гал түймэр				
Гал түймэр	Гал түймэртэй тэмцэх багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж авах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний тоноглолуудыг зохих газарт байнга бэлэн байлгах	Үйлдвэрийн хэмжээнд	300,0	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг MNS 5029:2011
ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ /мян.төг/			2300.0 мян.төг	

1.3. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	2026 он мян	Баримтлах стандарт, аргачлал
Хөрс, ус, агаарын бохирдол. Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх	Хог хаягдлыг ангилан ялгах, хогийн сав байршуулах, хог хаягдлыг зайлуулах гэрээ хийх	1000	Хог хаягдлын тухай хууль, хог хаягдлын талаар гарсан хүчин төгөлдөр эрх зүйн актууд
	Ажиллагсдад хог хаягдлын хууль эрхзүйн орчин, хог хаягдлын менежментийн чиглэлээр сургалт зохион байгуулах	3000	Монгол улсын шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 54/А/136/А/125 дугаар хамтарсан тушаал.
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний нийт зардал /мян.төг/		4000.0	

1.4. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

Төсөл хэрэгжүүлэгч нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүр тайланг хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллагад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлж, мөн түүнчлэн тухайн төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн аймаг, сумын иргэдийн хуралд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх танилцуулгыг хагас жил тутамд хийж байх шаардлагатай.

1.5. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

Хүснэгт 5. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
БОУАӨЯам	Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайлан, дараа оны БОМТ-ний төсөлтэй хамтатган БОУАӨЯ-нд хүргүүлнэ.	БОМТ-ний хэрэгжилтийн тайлан, гүйцэтгэл	Жил бүрийн 11 дүгээр сарын 1 –ний дотор илгээх	БОМТ-ийн хэрэгжилтийн тайланг хүлээн авч дүгнэлт гаргаж, дараагийн жилд хэрэгжүүлэх БОМТ-г хянан батална.	Төсөл хэрэгжүүлэгч
Төсөл хэрэгжих хорооны засаг дарга,	Хагас жилийн тайланг хүргүүлж, санал авах	Төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлсэн ажлуудын мэдээлэл	жил тутам	Тухайн жилийн БОМТ, түүний хэрэгжилт	
Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн Байгаль орчны хяналтын улсын					

байцаагч, орон нутгийн байцаагч					
Иргэд, олон нийт/дурын оролцогч, сонирхогч талууд	Санал хүсэлт хүлээн авч, төсөлтэй холбогдох гомдлыг шийдвэрлэж, барагдуулах	Байгаль орчны талаар гаргасан санал, гомдолтой холбогдол бүхий бүх төрлийн мэдээлэл	Төсөл хэрэгжих бүхий л хугацаанд	Сонирхогч, оролцогч талуудыг хүссэн мэдээллээр хангах	

ОРЧНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Тус төслийн 2025-2029 оны хоорондох 5-н жилийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрт Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусгасан болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор тогтмол дээжлэлт, сорьц авч байх үзүүлэлтүүд, дээж авах цэг байршил, хугацаа давтамж, баримтлах зарим гол стандарт, аргачлал, зардлыг тайлбарын хамт энэхүү орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав.

Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр нь байгаль орчин, нийгэм-эдийн засгийн үнэт зүйлсийг хамгаалах, түүнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа нь ямар үр дүнтэй байгааг илтгэх үндсэн баримт бичиг болно. Цаашдаа байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг улам боловсронгуй болгох байгаль орчин, нийгэм-эдийн засгийн болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг илүү нарийвчлан тогтоох боломжтой болно.

Тус хөтөлбөр нь төслийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртөх болон өртөж болзошгүй байгаль орчны бүрдэл хэсгүүд, тэдгээрийн төлөв байдлыг тодорхойлох үзүүлэлтүүд, төсөл хэрэгжих орчинд амьдардаг, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн амьжиргаа, нийгмийн болон эрүүл мэндийн байдлыг илтгэх гол үзүүлэлтүүд, тэдгээрт хэмжилт, дээжлэлт хийх шинжилгээний аргууд, хяналтын цэгийн байршил, хяналт хийх хугацаа ба давтамж зэргийг бүхэлд нь тусгасан Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний чухал хэсэг юм.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг төсөл хэрэгжүүлэгч хариуцна.

Хүснэгт 6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээний ажил	Нэгж зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг/жил	Баримтлах стандарт, арга, аргачлал	Хүлцэх зөвшөөрөгдөх хэмжээ агууламж,
Агаар орчны хяналт шинжилгээ				
Хянах үзүүлэлт: Агаар дахь тоосжилт PM2.5, PM10 Агаарын найрлага SO2, NO2, CO, Pb Давтамж: Улиралд тут амд Байршил: Үйлдвэр, оффис, агуулах талбайн агаарт орчноос	4 цэгт 4 удаа х 50,0	800.0	MNS 4585-2019 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга MNS5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга	PM 2.5-50 мкг/м³ 24 цаг, 25 мкг/м³жил, PM 10-100 мкг/м³ 24 цаг, 50 мкг/м³жил, SO2-20 мкг/м³ 24 цаг, 10 мкг/м³жил, NO2-40 мкг/м³ 24 цаг, 30 мкг/м³жил, CO-30000 мкг/м³ 1 цаг, 10000 мкг/м³38 цаг, Pb2- 1 мкг/м³ 24 цаг, 0.5мкг/м³ жил
Усан орчны хяналт шинжилгээ				

Хяналт шинжилгээний ажил	Нэгж зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг/жил	Баримтлах стандарт, арга, аргачлал	Хүлцэх зөвшөөрөгдөх хэмжээ агууламж,
Хянах үзүүлэлт: Усны чанар: рН, ууссан нийт давс (жингийн аргаар), нийт хатуулаг NH₄-N, NO₂-N, NO₃-N, PO₄-P, Cl, F, SO₄, Mn, Ni, Cu, Mo, Cd, Co, Pb, As, Cr, Cr⁶⁺, Zn, Hg, Эрдэс тос, Фенол, ГИНБ, Benzo (a) pyren Давтамж: Жилд хоёр удаа Байршил: Ажилчдын унд-ахуйн ус болон үйлдвэрлэлийн хэрэглээний уснаас	2 цэгээс 2 удаа х 46,0	184.0	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт	PH-6.5-8.5, NH₄-N0.5мгN/л, NO₂-N0.02мгN/л, NO₃-N9.0 мгN/л, PO₄-P0.1мгP/л, Cl300 мг/л, F1.5мг/л, SO₄100мг/л, Mn0.1мг/л, Ni0.01мг/л, Cu0.01, Mo0.25мг/л, Cd0.005мг/л, Co0.01мг/л, Pb0.01мг/л, As0.01мг/л, Cr0.05мг/л, Cr⁶⁺0.01мг/л, Zn0.01мг/л, Hg0.1мгк/л, Эрдэс тос0.05мг/л, Фенол0.001мг/л, ГИНБ0.1мг/л, Benzo (a) pyren0.005мкг/л
Хөрсөн орчны хяналт шинжилгээ				

Хяналт шинжилгээний ажил	Нэгж зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг/жил	Баримтлах стандарт, арга, аргачлал	Хүлцэх зөвшөөрөгдөх хэмжээ агууламж,
Хянах үзүүлэлт: Хөрсний бохирдол: Нүүрсустөрөгчийн нэгдлүүд буюу нефтийн бүтээгдэхүүн: Тиофенол, фенол, бензол, хөдөлгүүрийн тос, хар тулга Давтамж: Жилд 2 удаа Байршил: Үйлдвэрийн бохирдож болзошгүй орчин (хог түр хадгалах цэг, , автомашины зогсоол, агуулах талбай г.м)	3 цэгт 2 удаа 33,0	198.0	MNS 5850: 2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS (ISO) 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга	Хар тугалга (Pb) 100, Кадмий (Cd) 3, Мөнгөн ус (Hd) 2, Мишьяк (As) 6, Хром (Cr) 150, Зургаан валентат хром (Cr*6) 4, Цагаан тугалга (Sn) 50, Стронций (Sr) 800, Ванадий (V) 150, Зэс (Cu) 100, Никель (Ni) 150 Кобальт, (Co) 50, Цайр (Zn) 300, Молибден (Mo) 5, Селен (Se) 10, Бор (B) 25, Фтор (F) 200, Цианид (CN) 25 мг/кг, Тиофенол, фенол 4, газрын тосны бүтээгдэхүүн 2 мг/кг
НИЙТ ЗАРДАЛ		3.164.000		

